



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/102

Мандал

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Сүмбэр багт малын угаалгын ванн худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Балжинням (Хүнс худалдаа үйлчилгээ хоршооны хариуцсан мэргэжилтэн)

Гишүүн: Д.Дамдиндорж (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Б.Цэндбаяр (Санхүү албаны дарга)

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын дагуу цаг хугацаанд нь чанартай зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (С.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

